

ТАНИЛЦУУЛГА

“Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ын шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүнээс 2017 оны хоёрдугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд Төрийн албаны тухай хууль 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж байна.

Төрийн албаны тухай хуульд заасан төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацааг Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-аар, харин төрийн үйлчилгээний албанд туршилтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 23¹ дүгээр зүйлд зааснаар тус тус зохицуулагдаж байна.

Иймд журмын шинэчилсэн найруулгын төслийг Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн боловсруулав.

Журмын төслийг шинэчлэн боловсруулахдаа одоо хэрэгжиж байгаа журмын үйлчлэл, практикт гарч буй зөрчил, дутагдал болон АНУ /Луисиана мужийн/-ын болон Япон Улсын төрийн албанд туршилтын хугацаа хэрэглэх шаардлага, туршлага зэргийг судлан үзэв.

Энэхүү журмын төслийг хэлэлцэн баталснаар Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн төрийн жинхэнэ албанд анх орох иргэнд туршилтын хугацааг хэрэглэх нийтлэг болзол, шаардлагыг шинэчлэн тогтоох, туршилтын хугацаанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг боломжийг бүрдүүлнэ.

---oOo---

“ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТУРШИЛТЫН ХУГАЦАА ХЭРЭГЛЭХ БОЛЗОЛ, ЖУРАМ”-ЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацааг Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-аар, харин төрийн үйлчилгээний албанд туршилтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 23¹ дүгээр зүйлд зааснаар тус тус зохицуулагдаж байна.

Нэг. Журмын төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлага:

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журмыг төрийн албаны төв байгууллага батална гэж заасан.

Иймд одоо үйлчилж буй Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлал, агуулга, зарчимд нийцүүлэн, шинэчлэн боловсруулах хууль зүйн шаардлага гарч ирж байна.

Хоёр. Журмын төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү журмаар Төрийн албан тушаалд мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвартай иргэнийг төрийн албанд анх томилоход туршилтын хугацаа тогтоож, хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд дараах бүтэцтэй. Үүнд:

- Нэг.Нийтлэг үндэслэл,
- Хоёр.Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам,
- Гурав.Туршилтын хугацаанд ажилласан төрийн албан хаагчийг төрийн албан тушаалд томилох, чөлөөлөх,
- Дөрөв. Туршилтын хугацааны цалин хөлс,
- Тав. Бусад

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төрийн албаны тухай хуульд заасан “чадахуйн зарчим /мерит/-ын хэрэгжилтийг хангах, мөн төрийн албанд анх орох иргэнд туршилтын хугацааг хэрэглэх нийтлэг болзол, шаардлагыг шинэчлэн тогтоох, туршилтын хугацаанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалах, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох зэрэг эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна.

Журмын төсөл батлагдсанаар эдийн засгийн хувьд улсын төсөвт хүндрэл учруулах нөхцөх байдал үүсэхгүй болно.

Дөрөв. Энэхүү журмын төсөл нь Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай хэрхэн уялдах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал.

Энэхүү журмын төслийг Төрийн албаны төв байгууллага баталснаар Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг хүчингүйд тооцох юм.

Энэхүү журмын төсөл батлагдсантай холбоотойгоор үүнээс өөр өөрчлөгдөх болон хүчингүй болох хууль тогтоомж байхгүй болно.

----oOo----

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсгийг үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү журам батлагдсантай холбогдуулан “Журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦОГОО